



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Барилга байгууламжуудыг нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 128 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сонгинохайрхан, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон, нийт 308,573,354.00 (гурван зуун найман сая таван зуун далан гурван мянга гурван зуун тавин дөрөв) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг "Ус,сүвгийн удирдах газар" ОНӨААТҮГ (Ц.Төрхүү), Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв (Н.Эрдэнэбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110200262

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...01 дугаар... сарын ...15... өдрийн
...А/УС... захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглал-тад орсон он	Бүртгэх үнэ (төгрөг)	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Ус түгээх байр	Сонгинохайрхан дүүргийн 35 дугаар хороо	2023	130,417,151.00	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ
2	Халуун усны барилга байгууламж	Багануур дүүргийн 4 дүгээр хороо	2022	178,156,203.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Багануур дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв”
Нийт дүн				308,573,354.00		